



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар A/187

Мөрөн сум

Газрын талбайн хэмжээнд өөрчлөлт  
оруулж, эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны A/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын саналыг үндэслэн 2 иргэний гаргасан хүсэлтийн дагуу 0.1647га газрын талбайн хэмжээг 1 дүгээр хавсралтаар, 3 аж ахуйн нэгж, байгууллагын гаргасан хүсэлтийн дагуу 3.4133га газрын газар эзэмшүүлсэн аймаг, сумын Засаг даргын холбогдох захирамжийн газрын талбайн хэмжээнд 2 дугаар хавсралтаар тус тус өөрчлөлт оруулж, эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэнтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзүл) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар  
сарын 26....-ны өдрийн A/175 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨХ  
ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

| № | Иргэндийн овог,<br>нэр, регистр                          | Нэгж<br>талбарын<br>дугаар | Газрын<br>байршил     | Өөрчилж, нэмэлт оруулж буй захирамжийн<br>багана   | Тайлбар  |
|---|--|----------------------------|-----------------------|--|--|
| 1 | Бэсүд овгийн<br>Базаррагчаа<br>Догоодорж<br>/ИБ60052312/ | 6712015117                 | 7-р баг<br>26-8 тоот  | Аймгийн Засаг даргын 2014.04.17-ны өдрийн<br>A/149 дүгээр захирамжийн хавсралтын 9 дэх<br>заалтын 4 дэх баганын "54м <sup>2</sup> " гэснийг "74м <sup>2</sup> "<br>гэж   | Газрын талбайн хэмжээ<br>өөрчлөх<br>/хэмжилтээр/         |
| 2 | Шарнууд овгийн<br>Дүүжий<br>Лхамжаргал<br>/РН80040162/   | Шинээр                     | 7-р баг<br>31-15 тоот | Аймгийн Засаг даргын 2012.08.14-ний<br>өдрийн A/238 дугаар захирамжийн<br>хавсралтын 6 дахь заалтын 5 дахь багана,<br>Аймгийн Засаг даргын 2021.11.30-ны өдрийн<br>A/572 дугаар захирамжийн хавсралтын 5<br>дахь заалтын 5 дахь баганын талбайн<br>хэмжээг нэгтгэж "1573м <sup>2</sup> " гэж | 6712008559,<br>6712017027<br>нэгж талбараудыг<br>нэгтгэх |

Нийт талбайн хэмжээ-1647м<sup>2</sup>

ооо

Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар  
сарын 26.-ны өдрийн A/175 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨХ  
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

| № | Иргэндийн овог, нэр, регистр  | Нэгж талбарын дугаар | Газрын байршил              | Өөрчилж, нэмэлт оруулж буй захирамжийн багана   | Тайлбар   |
|---|---|----------------------|-----------------------------|---|---|
| 1 | Хөвсгөл аймгийн онцгой байдлын хэлтэс /РД:9073167/  | 6712008838           | 7-р баг ГТҮ-ийн баруун талд | Аймгийн Засаг даргын 2010.09.23-ны өдрийн A/349 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 3 дахь заалтын 5 дахь баганын "7257м <sup>2</sup> " гэснийг "7292м <sup>2</sup> " гэж  | Газрын талбайн хэмжээ өөрчлөх /хэмжилтээр/            |
| 2 | Зэвсэгт хүчний гурван зуун хорин тавдугаар ангийн гурван зуун хорин нэгдүгээр салбар /РД:9073183/ | 6712013634           | 13-р баг                    | Аймгийн Засаг даргын 2012.03.09-ний өдрийн A/50 дугаар захирамжийн хавсралтын 7 дахь заалтын 5 дахь баганын "19932м <sup>2</sup> " гэснийг "19654м <sup>2</sup> " гэж   | Газрын талбайн хэмжээ өөрчлөх /хэмжилтээр/            |
| 3 | Хөвсгөл аймгийн 5 дугаар цэцэрлэг /РД:9070249/  | Шинээр               | 3-р баг Мандал-1 105 тоот   | Аймгийн Засаг даргын 2012.05.21-ний өдрийн A/158 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтын 4 дэх заалтын 5 дахь багана, Аймгийн Засаг даргын 2022.04.01-ний өдрийн A/100 дугаар захирамжийн газрын талбайн хэмжээг нэгтгэж "7187м <sup>2</sup> " гэж | 6712008819,<br>6712017226<br>нэгж талбаруудыг нэгтгэх |

Нийт талбайн хэмжээ-34133м<sup>2</sup>

-----оо-----